

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 01 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл 2019 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

**Нэг.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг
тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил, үр дүн**

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор тус яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталж, 6 газар, 1 хэлтэс, 1 албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 309 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хууль 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын Их хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажилласан.

“Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай”, “Төрийн албан хаагчид шагнал, мөнгөн урамшуулал олгох, шагналд тодорхойлох журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журмыг шинэчлэн батлах тухай”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам батлах тухай” Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан тогтоолын төсөлд тус тус санал өгсөн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Стратеги төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах холбогдох судалгаа, бэлтгэл ажлуудыг хангаж, 2020 онд батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 2 дугаар хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн баталсан загварын дагуу боловсруулж батлуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019.02.18-ны А/28 дугаар тушаалаар харьяа агентлаг байгууллагын дарга, захирал, дэд дарга нарын албан тушаалын тодорхойлолт, Төрийн нарийн бичгийн даргын 2019.02.15-ны А/08 дугаар тушаалаар тус яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус байгуулж, албан тушаалын тодорхойлолтыг боловсрууллаа. Яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Улмаар тус яамны албан хаагчид болон харьяа агентлаг байгууллагын дарга, захирал, дэд дарга нарын албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн 2019 оны 69, 76, 390, 391 дүгээр тогтоолоор тус тус батлах зөвшөөрөл олгосон.

Тайлангийн хугацаанд тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нийт 6 удаа хуралдаж, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, 2019 оны дотоод сургалтын төлөвлөгөө, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг тус тус хэлэлцэн баталсан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ, 2019 оны дотоод сургалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 23 арга хэмжээ, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дарга, тэргүүн дэд, дэд дарга, захирал, тус яамны албан хаагчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарийн санал авч Хууль зүй, дотоод хэргийн сайдын Б/03, Төрийн нарийн бичгийн даргын Б/35 дугаар тушаалаар тус тус батлуулан хяналт тавин ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн програмд тус яамны 88 албан хаагчдын цалингийн мэдээллийг шинэчлэн оруулсан. Төрийн албаны зөвлөлийн албан даалгаврын биелэлтийг гарган танилцуулсан.

Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Салбар зөвлөлийн 2019.02.19-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Тус яамны Салбар зөвлөл 2019 онд 10 зорилтын хүрээнд 20 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилд төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжсэн.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөг газар хэлтсийн саналыг авч нэгтгэн ТАЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлуулсан.

Тайлангийн хугацаанд Салбар зөвлөлийн төлөвлөгөө, Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот албан бичгээр, яам болон харьяа байгууллагын албан хаагчдын 2018 оны хүний нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийн мэдээг 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, төлөвлөгөө, тайлан, Салбар зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудал, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүр цахим хуудаст байршуулан мэдээлсэн.

Гурав.Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

Тайлангийн хугацаанд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 6 /2019.02.18, 2019.04.16, 2019.05.24, 2019.09.02, 2019.09.30, 2019.12.24/ удаа хуралдсан. Хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

- 1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны төлөвлөгөөг хэлэлцэн батлах
2. ХЗДХЯ-ны албан хаагчдын 2019 оны дотоод сургалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
3. Хууль зүй, дотоод хэргийн яамны албан хаагчдад зориулсан “Нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2019 онд хийх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэлэлцэн батлах
4. Яамны төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээг үндэслэн зэрэг, дэв, цалингийн шатлал нэмэгдүүлэх тухай
5. Тус яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах
6. Ж.Вандансүрэнгийн гомдлыг хянан шалгасан Комиссын санал дүгнэлт
7. С.Даваадоржийн гомдлыг хянан шалгасан Комиссын санал дүгнэлт
8. Архивын ерөнхий газрын Үндэсний төв архивын захирлын албан тушаалд нэр дэвшигчдийн тухай
9. Г.Сэрээдарын гомдлыг хянан шалгасан Комиссын санал дүгнэлт
10. Архивын ерөнхий газрын Дэд дарга Ц.Гансүхийн цалингийн тухай
11. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төрийн тусгай албаны гүйцэтгэх албан тушаалд орох иргэнээс авсан тусгай шалгалтын дүнгийн тухай
12. Тус яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх батлуулах тухай
- 13.Тус яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах тухай
14. Тус яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт
- 15.Архивын ерөнхий газраас ирүүлсэн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцэн дүгнэлт гаргах тухай
- 16.Хууль зүйн туслалцааны төвөөс ирүүлсэн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хэлэлцэн дүгнэлт гаргах тухай
- 17.“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар нэр дэвшүүлж, Төрийн албаны зөвлөлд уламжлах тухай /УБЕГ, АЕГ-аас нэр дэвшүүлж ирсэн/
- 18.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тухай

Хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолын төсөл 15-ыг боловсруулан батлуулсан.

Хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг тооцон хяналт тавин ажилласан.

Дөрөв. Орон нутаг, салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Салбар зөвлөлөөс харьяа агентлаг, байгууллагад 2019 оны 03 дугаар сарын 19-ний 1-4/1163, 04 дүгээр сарын 24-ний 1-4/1801, 06 дугаар сарын 1-4/ тоот албан бичгээр

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай холбоотой мэдээ, мэдээлэл өгч, чиглэл хүргүүлсэн.

Мөн Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, хуультай холбоотой батлагдан гарсан дүрэм, журмын хүрээнд хийж байгаа арга хэмжээний тайланг авч, удирдлагад танилцуулсан. Тус яамны харьяа агентлаг, байгууллагууд дараах чиглэлийн хүрээнд төлөвлөгөө гарган ажилласан. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, шинээр батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр хийж байгаа ажил

-Төрийн албаны хууль бус томилгоог засч хуульд нийцүүлэн залруулах чиглэлээр хийсэн ажил

-Цаашид тухайн байгууллагын хүний нөөцийн нөхөн хангалтын талаарх мэдээ, тайлан

-Төрийн албан хаагчид зэрэг дэв олгох ахиулах, цалингийн шатлал нэмэгдүүлэхдээ холбогдох шаардлагыг харгалзан үзсэн эсэх

-Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам, загварын дагуу албан хаагчдынхаа албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах чиглэлээр хийж байгаа ажил

-Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил

-Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн байдал

Тав.Салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/167 дугаар тушаалаар тус яамны албан хаагчдын ажлын байрны шинжилгээний асуулга, баримт бичгийн судалгаааны үр дүнг харьцуулан шинжилж боловсруулалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүнээр ахлуулан байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн албан хаагчдын ажлын байрны шинжилгээний асуулга, баримт бичгийн судалгаааны үр дүнг харьцуулан шинжилж, судалгаааны тайланг илтгэх хуудсаар гарган танилцуулж, дүнг ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Тус яамны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/47 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу тус яамны газар, хэлтсийн чиг үүрэгт үнэлгээ хийж, дүнг танилцуулсан.

Чиг үүргийн шинжилгээний гол зорилт нь ажил тус бүрийг “Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т нийцүүлэн ач холбогдлоор нь эрэмбэлж, Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн, тус ажлыг ямар ангилалын албан тушаалтан эрхлэн гүйцэтгэхийг тодорхойлох, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, давхардал хийдлийг арилгах, чиг үүрэг давхардсан ажлын байрыг нэгтгэх, хуулиар хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэх чадварлаг, цомхон хүний нөөцийг бий болгох, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх явдал байсан бөгөөд шинжилгээний дүгнэлтэд үндэслэн тус яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулсан.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 09 тоот тогтоолоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм, журмын хэрэгжилтийг шалган зааварлах, арга зүйн зөвлөгөө өгөх Ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Зургаа.Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны төлөвлөгөөг газар хэлтсийн албан хаагчдаас санал авч, албан хаагчдын хэрэгцээг үндэслэн ТАЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлуулсан.

Төлөвлөгөөний дагуу Засгийн газрын тэтгэлэгт урт хугацааны сургалт, Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн сургалт, урт, богино хугацааны гадаад сургалт, ажлын байран дахь болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулах сургалт гэсэн 4 чиглэлийн дагуу албан хаагчдын сургалтыг зохион байгуулсан.

Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг сургалт”-д тус яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн М.Цолмон, Дотоод хэргийн их сургуулийн докторантурын сургалтад Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Ц.Нугармаа, Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Н.Нарангарав, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны мэргэжилтэн Б.Баяндүүрэн нар тус тус хамрагдсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академиас зохион байгуулсан сургалтуудад албан хаагчдыг хамруулах ажлыг тухай бүр зохион байгууллаа. Тухайлбал, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулж, яам болон Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагын нийт 223 албан хаагчийг хамруулсан.

Дотоод сургалтын хүрээнд дараах сургалтыг зохион байгуулсан Үүнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах шалгуур үзүүлэлт тогтоох, тайлагнах, анхаарах асуудал
- Англи хэлийг хэрхэн үр дүнтэй сурах вэ?
- Архивын улсын үзлэгт бэлтгэх чиглэл
- Технологи хуулийн салбарт
- Хөрөнгийн зах зээлийн анхан шатны сургалт:1072 хувьцааны ойлголт, мэдээлэл, зөвлөгөө зэрэг сургалтуудыг зохион байгуулсан.

Дотоод сургалтаас гадна ажилтнуудад Ундны усны чанар, аюулгүй байдал, Амны хөндийн эрүүл мэнд, Сүрьеэ өвчнөөс сэргийлэх, Ус, хөрсний бохирдол эрүүл мэндэд нөлөөлөх нь сэдвээр мэдээллийн цагийг мэргэжлийн багшаар хийлгүүлж, дотоод сүлжээнд эрүүл мэндийг зөвлөгөө, зөвлөмжийг тухай бүр байршуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар байгуулагдсан шалгалтын Комисс ОХУ-ын ДХЯ-ны харьяа академи, их, дээд сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд бакалаврын болон магистрантур, адъюнктурын сургалтад элсүүлэх сонгон шалгаруулалтыг 2019 оны 03 дугаар сарын 12-ноос 03 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулж, дүнг илтгэх хуудсаар Сайдад танилцуулсан.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн 24 алба хаагч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Суралцуулах тухай А/51 дүгээр тушаалаар ОХУ-ын ДЯЯ-ны харьяа, академи, их, дээд сургуульд эрх зүй, хууль сахиулах, сэтгэл зүй, шүүхийн шинжилгээ, радио холбоо, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, удирдлагын чиглэлээр суралцахаар шийдвэрлэгдсэн.

2019 онд 1 албан хаагч гадаадад урт хугацааны сургалтад, давхардсан тоогоор 18 албан хаагч гадаад улсад богино хугацааны сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд, 124 албан хаагч дотоодод богино хугацааны сургалтад хамрагдсан.

Долоо.Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн

а/Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд

2019 онд 2 албан хаагч шилжин, 1 албан хаагч сэлгэн томилогдож, 12 албан хаагч Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөгдсөн. Мөн 1 албан хаагч гадаадад урт хугацааны сургалтад, давхардсан тоогоор 18 албан хаагч гадаад улсад богино хугацааны сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд, 124 албан хаагч дотоодод богино хугацааны сургалтад хамрагдсан.

Тус яамны албан хаагчдад зэрэг дэв олгох, ахиулах, цалингийн шатлал нэмэгдүүлэх саналыг 2018 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг үндэслэн удирдлагад танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны Б/12 дугаар тушаалаар 13 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах болон шинээр олгосон.

Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/15 дугаар тушаалаар 13 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн бөгөөд тус яамны нэгжийн дарга нарт зэрэг дэв олгох саналыг үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ, тавигдах шаардлагыг харгалзан эрх бүхий байгууллагад уламжлуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 90 дүгээр захирамжаар 3 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг олгосон.

б/ Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах хүрээнд

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг газар хэлтсийн саналыг авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Салбар зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлуулсан.

Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг “Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах”, “Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах”, “Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх”, “Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрыг хөгжүүлэх” 4 зорилтын хүрээнд 15 ажлыг хийхээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан.

Албан хаагчдыг 2019 оны 03 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, илрүүлэг, шинжилгээнд 2 үе шаттайгаар хамруулсан. Нийт 57 албан хаагч хамрагдсан.

Албан хаагчдыг ээлжийн амралтаараа Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Аварга тосон дахь “Хилчин” амралт сувилал, Цагдаагийн ерөнхий газрын харьяа “Сүүж-Уул” сувилалд /гэр бүлийн хүмүүсийн хамт/ хөнгөлттэй үнээр амрах ажлыг зохион байгуулсан.

“Яамны албан хаагчдын спортын тэмцээн”, “Засгийн газрын цом-2019” тэмцээн, “ХЗДХЯ болон харьяа агентлаг, байгууллагын тэмцээн” тэмцээнүүдийг зохион байгуулж, идэвхтэй оролцсон.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн зааланд 7 хоног бүрийн “Баасан” гарагт спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.

в/Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх хүрээнд

“Алба хаагч бүрт орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар тус яамны үйлчилгээний 8 албан хаагчид орон сууц олгох ажлыг зохион байгуулсан.

Олон улсын ахмадын баяр, Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан тус яамны 32 ахмад настанг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх, хүүхдийн баяр, шинэ жилээр яамны албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардуулах, гэр хороололд амьдардаг албан хаагчдад түлээ, нүүрсний тусламж үзүүлэх ажлыг тус тус зохион байгуулсан.

Найм.Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Тус яамны сул орон тоонд албан хаагчийг томилохдоо Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс баталсан журмын дагуу төрийн жинхэнэ албаны шалгалт өгсөн, төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс шалгаруулан томилгоог хийсэн бөгөөд 2019 онд холбогдох дүрэм, журмын дагуу 5 албан хаагчийг сэлгэн, шилжүүлэн, түр орлон гүйцэтгэгчээр томилсон. Тайлангийн хугацаанд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт болоогүй болно.

Ес.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Салбар зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 08 тогтоолоор Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн төрийн тусгай албан тушаалын сул орон тоонд

ажиллах сонгон шалгаруулалтыг нээлттэй зарласан. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Комиссыг Салбар зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор байгуулан ажилласан.

Арав.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам, загвар батлах тухай” 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан загварын дагуу төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлэн ажиллаж байна.

Арван нэг.Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлэн ажиллаж байна.

2019 онд томилогдсон 5, төрийн бусад байгууллагад сэлгэн ажилласан 3, төрийн албанаас чөлөөлөгдсөн 12 /урт хугацааны сургалтад хамрагдсан, өөрийн хүсэлтээр, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн/, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд 10 албан хаагч байна.

Хөлсөөр ажиллах гэрээгээр ажилладаг үйлчилгээний 9 албан хаагчийн гэрээг сунган баталгаажуулж, шинээр 10 албан хаагчтай Хөлсөөр ажиллах гэрээ байгуулсан.

Арван хоёр.Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал

Улсын Их Хурлын 2017 оны 29, 2016 оны 47, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолоор төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай үүрэг чиглэл өгсөнтэй холбоотойгоор тус яамны албан хаагчдад зэрэг дэв олгох, ахиулах, цалингийн шатлал нэмэгдүүлэх саналыг 2018 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг үндэслэн удирдлагад танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны Б/12 дугаар тушаалаар 13 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах болон шинээр олгосон.

Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/15 дугаар тушаалаар 13 албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн бөгөөд тус яамны нэгжийн дарга нарт зэрэг дэв олгох саналыг үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ, тавигдах шаардлагыг харгалзан эрх бүхий байгууллагад уламжлуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 90 дүгээр захирамжаар 3 албан хаагчид Эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг олгосон.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу

байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган үр дүнтэй ажиллаж байгаа албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Тухайлбал, 5 албан хаагчийг Хууль зүйн албаны тэргүүний ажилтан, 8 албан хаагчийг Хүндэт жуух бичгээр шагнаж урамшуулсан.

Арван гурав. Ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Тус яамны нийт албан хаагчдаас нээлттэй санал авч, Салбар зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор тус яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг дотоод сүлжээ болон мэдээллийн самбарт байршуулан нийт албан хаагчдад танилцуулсан.

Арван дөрөв. Өргөдөл, гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлсэн байдал

Тайлангийн хугацаанд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 өргөдөл гомдол ирсэн байна. Улсын Их Хурлын 2019 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын дагуу хянан шийдвэрлэсэн.

Иргэн Ж.Вандансүрэн, С.Даваадорж, Г.Сэрээдар нарын гаргасан гомдлыг хянан үзэж, Салбар зөвлөлийн тогтоолоор хариу өгсөн.

Арван тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн

Тус яамны албан ёсны <http://www.mojha.gov.mn> цахим хуудсанд Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн танилцуулга, тайлан, үйл ажиллагааны талаар мэдээлэл, цаг үеийн шинжтэй мэдээнүүдийг тухай бүр байршуулан ажилласан.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмуудыг Able дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулсан.

Арван зургаа. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, мэдээ ирүүлсэн байдал

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот албан бичгээр, яам болон харьяа байгууллагын албан хаагчдын 2018 оны хүний нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийн мэдээг 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Арван долоо.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөн харьяа агентлаг, байгууллагад Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл хүргүүлсэн.

Арван найм.Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн/иргэдийн/ үнэлгээ

Тус яамны албан ёсны <http://www.mojha.gov.mn> вэб сайтад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн танилцуулга, тайлан, төлөвлөгөө, үйл ажиллагааны талаар мэдээлэл, цаг үеийн шинжтэй мэдээнүүдийг оруулж, иргэд танилцах боломжоор ханган ажиллаж байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар иргэдээс тухайлан санал ирүүлээгүй.

Арван ес.Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал

Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайланг 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот албан бичгээр, яам болон харьяа байгууллагын албан хаагчдын 2018 оны хүний нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийн мэдээг 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн програмд албан хаагчдын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулж баталгаажуулсан. Мөн тус яамны албан хаагчдын цалингийн мэдээллийг шинэчлэн оруулсан.

Хорь.Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт

Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн үүрэг, даалгаврын биелэлтийг 2019.03.29-ний 05, 2019.06.10-ны 09, 2019.06.27-ны 10, 2019.12.21-ний 16 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Салбар зөвлөлөөс харьяа агентлаг, байгууллагад Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай холбоотой мэдээ, мэдээлэл өгч, зөвлөмж, чиглэл хүргүүлсэн. Тухайлбал, Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны стандарт зөрчсөн үйлдлийг нэн даруй арилгаж цаашид зөрчихгүй байх, төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааны хэрэгцээг оновчтой тодорхойлсоны үндсэн дээр “Төрийн албан хаагчийн сургалт”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа”-ны хөтөлбөрийг боловсруулж батлах, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг тооцон ажиллах, албан хаагчдыг ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллуулах, төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, манлайлах

ур чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулах, төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр зөвлөмж хүргүүлэн биелэлтийг тооцон ажилласан.

Хорин нэг. Төрийн байгууллагуудад хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг арилгуулах, сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн

Тус яам үйл ажиллагаандаа шинэ хуулийн зарчмыг нэвтрүүлэх, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн томилгоонд төрийн жинхэнэ албан хаагчдаас мэргэшлийн түвшингээр шалгаруулж, томилох зарчмыг баримтлан ажиллаж байна.

Эрхэлсэн асуудал, хариуцсан ажлын хүрээнд мөрдөгдөх хууль тогтоомжийг хэрэгжүүлж, сахилга дэг журмыг сахин ажиллах, авлига, түүний хор уршгийн талаар мэдээ, мэдээлэл олж авах, өөрийгөө болон бусад албан хаагчийг авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд, үнэн зөв гаргаж өгөх талаар албан хаагчдад мэдээлэл өгч, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу яамны хэмжээнд 2019 онд төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн, ажилдаа хариуцлагагүй хандсан, ажлын цаг ашиглалт зөрчсөн 8 албан хаагчид хариуцлага тооцож, сахилгын арга хэмжээ авсан. Сахилгын арга хэмжээ оногдуулсан шийдвэрийг нийт албан хаагчдын хурал болон дотоод сүлжээнд байршуулан мэдээлсэн. Шийдвэрийн хуулбарыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Цаашид албан хаагчдын цаг ашиглалтын байдалд байнга хяналт тавин ажиллаж, цагийн бүртгэлийг 14 хоног тутам гарган Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн ажиллаж байна.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ**